

## "УЧИРТАЙ ГУРВАН ТОЛГОЙ" БА GUSTAV FREYTAG'S PYRAMID

Ж.Ууганбаатар  
(Монгол Улс, ШУА, Хэл зохиолын хүрээлэн)

Өрнө дахины жүжгийн онолын сэтгэлгээнд Густав Фрейтаг томоохон байр эзэлдэг. Учир нь тэрээр жүжгийн зохиолын үйл явдлын бүтэц байгууламжийг эхлэлээс, төгсгөл нь хүртэл тодорхойлсон загварыг бий болгосон. Жүжгийн зохиолд янз бүрийн зөрчилт үйл явдлыг үзүүлдэг, сэдэв, утга санаа, дүр, дүрслэл, арга дэгийн хувьд чөлөөтэй байдаг ч гэлээ, зөрчлийг шийдвэрлэх үйл явдлын давтамж нь хэвшин тогтсон дараалалтай, бүтэц нь тогтмол, хувирашгүй “төрөлхийн” байдаг. Зохиолын байгууламж нь хэдийчинээ зөв, зохистой байна, зохиол нь төдийчинээ нягт, зөв логиктой, сонирхолтой болно.

### **Фрейтагийн пирамид ба Аристотелийн үйл явдлын нэгдмэл гурвалжин**

Аристотель “*Туурвил зүй*” хэмээх бүтээлдээ драмын нэгдмэл үйл явдлын бүтцийг гурвалжин хэлбэрээр үзүүлж, зүүн гар талын доод хэсгийг грекээр *protasis* буюу УДИРТГАЛ, оройн хэсгийг *epitasis* нь ЗӨРЧЛИЙН ТУЙЛ, баруун талын доод хэсгийн *catastrophe* буюу ЗӨРЧЛИЙН ШИЙДЭЛ хэмээн өгүүлжээ. Тэгвэл Г.Фрейтаг “Аристотелийн гурвалжин”-г цааш пирамид болгон хөгжүүлж, “*үйл явдлын өсөлтийн шат*”, “*үйл явдлын уналтын шат*” гэсэн хоёр түвшинг нэмснээр пирамид таван хөвчөөс бүрдэнэ. Энэхүү таван хөвчийг үйл явдлын бүтцийн анализ хийхэд ашиглаж, зүүн доод талыг удиртгал (тайлбар), зүүн дунд талыг үйл явдлын өсөлт, оройн хэсгийг оргил (эргэлтийн цэг), баруун дунд талыг үйл явдлын уналт, баруун доод талыг шийдэл (төгсгөл) гэж нэрлэсэн ба зохиомжийн бүтцийг боловсруулах, танин мэдэхэд хамгийн дөхөм болохуйц сонирхолтой загвар юм. Жүжиг хөгжлийнхөө явцад өнөөг хүртэл зохиомж, бүтцийн хувьд баяжин, өөрчлөгдөж өгүүлэгдэхүүний олон хэлбэр лүү шилжин хувьссаар ирсэн.

Аливаа жүжигт зөрчилт үйл явдал, зөв харилцан яриа чухал. Жүжгийн зөрчилт үйл явдал I үзэгдэлд гол дүр, сэдэв, утга санаа, асуудал, зөрчил тэмцэлтэй шууд хамааралтай онцгой нэгэн үйл явдлыг эхлүүлж, ихэвчлэн III үзэгдэлд зайлахын аргагүй дээд зэргийн туйл бүхий хямралыг үүсгэн өрнүүлж, төгсгөлийн үзэгдэлдээ энэ бүхнийг аль нэг тийш нь шийдэж, үр дүнд хүргэдэг байна. Ингэж жүжигт эхлэлээс төгсгөл хүртэл өрнөх үйл явдлын тодорхой дараалал, бүтэц байдаг нь уран зохиолын бусад төрөл зүйлээс ялгарах онцлогийн нэг юм. “Фрейтагийн пирамид”-ийн эмгэнэлт жүжгийн загвараар дэлхийн сонгодог эмгэнэлт жүжгийн үйл явдлын бүтцийг задлан шинжлэх, танин мэдэхэд, судалгааны аргазүйн хувьд сонирхолтой үр дүн гардаг учир зарим судлаачид өргөнөөр ашигладаг.

XX зууны монгол жүжгийн зохиол сэдэв агуулга, дүр дүрслэлийн хувьд дорно дахины өнгө аястай, уламжлалаа хадгалан хөгжих боловч хэлбэр зохиомж, бүтцийн хувьд өрнө дахины жүжгийн туурвил зүйн арга маягтай нэгэн хэлбэрт оршиж байгааг Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” эмгэнэлт жүжгээр төлөөлүүлэн авч үзэв. “Фрейтагийн пирамид”-ийн эмгэнэлт жүжгийн бүтцийн загварыг ашиглан жүжгийн зохиомж, үйл явдлын бүтцэд ажиглалт хийснээр нэг талаас жүжиг бол уран зохиолын төрөл зүйлийн дотроос хамгийн тогтолцоотой, жүжгийн зохиолын бүтэц харьцангуй тогтвортойг харуулж, нөгөө талаас монголын орчин үеийн жүжгийн туурвилзүй дэлхийн уран зохиолын туурвилзүйн сэтгэлгээтэй хамт оршиж байна гэдгийн баталгаа юм.